

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАГВАР, ТӨЛНИЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

A COMPARATIVE STUDY OF POLICING MODELS

Д.Булган. Хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор
цагдаагийн дэд хурандаа

Bulgan D. (Ph.D). Police Lieutenant Colonel

Товчлол: Дэлхийн улс орнуудад цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бөтэц нь уламжлал, нийгэм, соёл, төрийн байгууламжийн онцлогоос хамааран өөр өөр хөгжсөн бөгөөд хоорондоо их ялгаатай байдаг. Монгол Улс нь Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэд нэгдмэл төвлөрсөн зохион байгуулалттай цагдаагийн байгууллагатай, харин зарим орон тухайлбал, БНХАУ, Энэтхэг, Саудын араб, АНУ зэрэг улс орнуудын цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бөтцийн загвар нь зарчмын хувьд төвлөрсөн, төвлөрсөн бус цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай өөр өөр зохион байгуулагдаж байна. Энэ онцлогийг тодорхойлохын тулд Саудын Араб, Хятад, Их Британи, Испани, Америкийн Нэгдсэн Улс, Энэтхэг зэрэг орны цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын загварыг харьцуулан үзэж, төрийн орны онцлогтой харьцуулан судаллаа.

Төлхөөрөг: Цагдаагийн байгууллагын зохион байгуулалт, бөтэц, тогтолцоо, загвар.

Удиртгал. Монгол Улсад төрийн байгууллагын зарим өөрчлөлтөөр 1990 онд цагдан сэргийлэхийг Нийгмийг аюулаас хамгаалах Яамны харьяанаас гаргаж, Засгийн газрын дэргэд Цагдан сэргийлэх ерөнхий газрыг байгуулсан нь цагдаагийн байгууллагыг тагнан турших байгууллагын системээс тусгаарлаж, бие даалгасан чухал алхам хийж, нөхцөлийн орчин үеийн цагдаагийн байгууллагын хөгжих эхний алхам болсон.

Цагдаагийн байгууллага нь гүйцэтгэх эрх мэдлийн тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд хууль сахиулах салбарын эрх

хэмжээтэй, байнгын бэлэн байдалд ажилладаг тѳрийн тусгай байгууллага юм¹.

Цагдаагийн байгууллага нь гѳйцэтгэх эрх мэдлийн хууль зѳй, дотоод хэргийн салбарын удирдлагын хѳрээнд тѳрѳс ѳзѳлэх “олон нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” ѳйлчилгээг иргэдэд хѳргэхэд чиглэсэн, хуулиар хѳлээлгэсэн чиг ѳѳргийг гѳйцэтгэх зорилготой, тэдгээрийг хэрэгжѳлэх эрх мэдэл хуулиар олгогдсон, зохион байгуулалтын тогтолцоо^{1 2} юм.

Цагдаагийн байгууллагаас иргэд, олон нийтийн аюулгѳй, амар тайван амьдралын баталгааг хангахын тулд ѳйл ажиллагаагаа байнга шинэчилж, хѳгжѳлэх, боловсронгуй болгох нь зайлшгѳй юм. Тиймээс энэхѳ сэдвийг дараах ѳндэслэлээр судаллаа. ѳѳнд:

1. Монгол Улсад “Цагдаагийн албаны тухай хууль” 1993, 2013, 2017 онд батлагдсан бѳгѳд цагдаагийн байгууллагын зохион байгуулалтыг бѳтцийг тодорхойлох ѳндсэн зарчмыг нэгдмэл тѳвлѳрсѳн удирдлагатай байдлыг тодорхойлж, ѳр нѳлѳг дээшлѳлэхэд чиглэсэн. Эдгээр хуульд гэмт хэрэг, зѳрчлѳс урьдчилан сэргийлэх ажлын тѳрѳл, чиглэлийг хэрхэн тусгасныг дараах хѳснэгтээр харьцуулан ѳзье.

Хүснэгт №1.Цагдаагийн албаны зохион байгуулалтын бүтэц.

Цагдаагийн албаны тухай хууль /2013/	Цагдаагийн албаны тухай хууль /2017/
4 дүгээр зүйл.Цагдаагийн албаны үйл ажиллагаа, удирдлагын үндсэн зарчим 4.1.Цагдаагийн алба, алба хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ... мэдээллийн сүлжээний ололтыг ашиглах, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх үндсэн зарчмыг баримтална.	5 дугаар зүйл. Цагдаагийн албаны үйл ажиллагаа, удирдлагын зарчим 5.1. Цагдаагийн алба, алба хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ... улс төрөөс ангид байх, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг баримтална.

¹ Долгорсѳрэн Ж, Булган Д. Монгол Улсын цагдаагийн эрх зѳйн курс. УБ., 2014 он.
.. дэх тал

² Цагдаагийн албаны тухай хуулийн 3 дугаар зѳйлийн 3.1 дэх хэсэг “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгѳй байдлыг хангах ѳндсэн чиг ѳѳрэг бѳхий хууль сахиулах байгууллага мѳн”. //Тѳрийн мэдээлэл. 2015. №8.

5 дугаар зүйл. Цагдаагийн
байгууллагын тогтолцоо

5.1. Цагдаагийн байгууллага нь цагдаагийн тив байгууллага, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, харьяа нэгжээс бүрдэнэ.

6.3. Цагдаагийн тив байгууллагын харьяа алба, нэгж нь хариуцсан чиг үүргийн хүрээнд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаагаа цагдаагийн тив байгууллагын даргын үйл хариуцан тайлагнана.

6 дугаар зүйл. Цагдаагийн
байгууллагын тогтолцоо

6.1. Цагдаагийн байгууллага нь цагдаагийн тив байгууллага, түүний харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас бүрдэнэ.

5.3. Цагдаагийн тив байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах болон дэмжлэг үзүүлэх зохион байгуулалтын бүтцийн нэгжээс бүрдэнэ.

Хүснэгтээс харахад цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг тодорхойлох үндсэн зарчим буюу “нэгдмэл тивлүүлсэн удирдлагатай байх” зарчмыг тусгасан байна. Энэхүү зарчимд үндэслэн цагдаагийн ерөнхий газрын харьяа анги, салбар, тээврийн цагдаагийн зэрэг чиг үүргийн байгууллагаас бусад цагдаагийн бүх байгууллага нь энэ зарчмын дагуу зохион байгуулагдаж ажилладаг. Үүрх хэлбэл, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид нийцүүлэн дүүргийн буюу дүүрэг, сум дундын цагдаагийн хэлтэс, нэн ялангуяа тасаг, хэсэг нь тодорхой нутаг дэвсгэр хариуцаж зохион байгуулагдсан.

2. Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг тодорхойлоход нутаг дэвсгэрийн нэгжийн газар зүйн байрлал, хүн амын тоо, нүүдэл суурьшил, эдийн засгийн бүтцийн байдал, гэмт хэрэг, нийтийн хэв журмын зөрчлийн гаралт, хөдөлгөөн, тархалтыг заавал харгалзан үздэг¹. Монгол Улсад 2019 онд 31524, 2020 онд 23064, 2021 онд 23348 гэмт хэрэг бүртгэгдсэн нь үүнх оноос 3.7 хувиар өссөн нь статистик судалгаанаас харагдаж байна². 2021 онд хүнгүй гэмт хэрэг, үүнх оноос 8.7 хувиар өссөн, хүнд гэмт хэрэг үүнх оноос 20,5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын тогтолцоо, хүн хүч, техник хэрэгсэл, үйл ажиллагаанд үүрчлөлт орж, тодорхой ажлуудыг

¹ Долгорсүрэн Ж. Булган Д. Монгол Улсын цагдаагийн эрх зүйн курс. УБ., 2014 он.

² Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2019, 2020, 2021 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. <https://police.gov.mn/as/static>

зохион байгуулсаар ирсэн ч зарим төрлийн гэмт хэрэг буурахгүй байгаа нь статистик судалгаанаас харагдаж байна. Тиймээс ч гадаадын улс орнуудын зохион байгуулалтын онцлогийг судалж, нэвтрүүлэх нь төр нийгэм дээшлүүлэх арга замыг бий болгоход чухал ач холбогдолтой. Улс орон бүр өөр өөр орчин нөхцөлтэйгээс гадна төрхөн хөгжил, нийгэм эдийн засаг, соёл, эрх зүйн тогтолцооны хувьд ялгаатай учраас өөрийн онцлогт тохирсон цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн загвар, менежментийн тогтолцоог бүрдүүлдэг.

Төнтэй уялдаатайгаар цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, загварын талаарх гадаадын зарим орны цагдаагийн байгууллагын загварын онцлогийг харьцуулан судалж, холбогдох нэр томьёо, төрний агуулга, тэдгээрийн зааг ялгааг гаргаж, судалгааны эргэлтэд оруулах, хөгжүүлэхэд энэхүү гүйцэтгэлийн зорилго чиглэнэ.

Үндсэн хэсэг. Цагдаагийн байгууллагын үндсэн үүрэг нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, төнтэй тэмцэх, хөнөөлийн үндсэн эрх, эрх чөлөөг хөндөтгэн дээдлэх, амар тайван байдал болон хэв журам, хуулийг сахиулах, олон нийтэд ийлчилгээ, тусламж үзүүлэх явдал юм¹. Өөрсөрсө хэлбэл, цагдаагийн байгууллагын ийл ажиллагаа нь нийгэмд мэргэжлийн ийлчилгээг хөн амын хэрэгцээнд нийцсэн, хариуцлагатай, төр дөнтэй ийлчилгээ үзүүлэх явдал юм.

Европын зөвлөлийн “Цагдаагийн ёс зүйн Европын хууль”²-ийг бий болгосон. Энэхүү хуулиар цагдаагийн байгууллагын үндсэн зорилгод дараах зүйлийг тодорхойлжээ.

- Олон нийтийн амар тайван байдал, нийгэмд хууль, дэг журам сахиулах;
- Хөний суурь эрх, эрх чөлөөг хөндөтгэх, хамгаалах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх;
- Гэмт хэрэг илрүүлэх;
- Олон нийтэд тусламж, ийлчилгээг үзүүлэх гэжээ.

Энэхүү ёс зүйн хуульд цагдаагийн байгууллагын үндсэн зорилт, чиг үүргийн талаар заасан бүгд үүргийн талаарх

¹ Monica den Boer, Changwon Pyo. “Good Policing: Instruments, Models and Practices” ISBN : 978-981-08-8126-9, Copyright@ 2011, p 17.

² European Code of Police Ethics, www.polis.osce.org

харилцааг зохицуулжээ. Энэ нь нийгэм дэх амар тайван байдлыг бий болгож, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалснаар олон нийтийн аюулгүй байдлыг хангах нндэс суурь бүрдэхээр заасан.

Цагдаагийн байгууллага нь Засгийн газрын, Хууль зүй, дотоод хэргийн яамны шууд харьяа байгууллага юм. Энэ нь “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдэвч”¹-ийг батлах тухай УИХ-ын 2020 оны 07 дугаар тогтоолоор баталгаажиж, Цагдаагийн ерөнхий газар нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын тохируулагч Агентлаг байхаар тогтоосон.

Цагдаагийн төв байгууллагын дарга цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, үр дүнг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний үмн², нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга үйл ажиллагаагаа цагдаагийн төв байгууллагын даргын үмн³ тус тус хариуцахаар Цагдаагийн албаны тухай хуульд заасан. Мөн тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “цагдаагийн алба, алба хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын үндсэн хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж, дэмжлэг авах, үйл ажиллагаа нь тасралтгүй байх, улс төрөөс ангид байх, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг баримтална” гэж заасан. Цагдаагийн төв байгууллага уг зарчмыг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын үндсэн хууль, хууль тогтоомж, төнд нийцсэн бусад акт, тэдгээрт нийцүүлэн доод шатны байгууллагын үйл ажиллагааг удирдахын зэрэгцээ үйл ажиллагааныхаа арга, хэлбэрийг боловсронгуй болгох, тэргүүн туршлага, арга барилыг судалж дэлгэрүүлэх, боловсон хүчин, зэвсэг техник, тусгай хэрэгсэл, бусад материалаар хангах ажлыг чиглүүлдэг. Мөн “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 16 дүгээр зүйлийн 16.5-д “Засгийн газар болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас цагдаагийн байгууллагатай харилцах

¹ Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдэвчийг шинэчлэн батлах тухай Монгол Улсын их хурлын тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail/15488>

² Цагдаагийн албаны тухай хууль. 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт. <https://legalinfo.mn/mn/detail/12469>

³ Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.

талаар энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан бэрхшээл эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан нь дагуу нутаг дэвсгэрийн удирдлага холбогдох хууль тогтоомжийн цагдаагийн байгууллагын ийл ажиллагааг удирдан чиглүүлж, орон нутгийн нийгмэл, онцлогийг харгалзан хүн ам, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй харьцаж холбоогоо бүрдүүлэх, бэхжүүлэхэд нь илэр тутмын практик туслалцаа үзүүлдэг.

Цагдаагийн тогтолцооны талаарх харьцуулсан судалгаа:

1. Саудын Араб: Саудын Арабын цагдаагийн байгууллага нь Хааны удирдлаган дор төвлөрсөн, цагдаагийн хүчний ердийн зохион байгуулалтын загвар юм. Дотоод хэргийн сайд, Олон нийтийн аюулгүй байдлын дарга (цагдаагийн дарга)-ыг Хаан томилдог бөгөөд аль аль нь хааны гэр бүлийн ахмад гишүүд байдаг. Олон нийтийн аюулгүй байдлын (public security) цагдаа нь улс орон даяар цагдаагийн ажлыг хариуцан хэрэгжүүлдэг. Мөн олон нийтийн аюулгүй байдлын цагдаа нь “энгийн цагдаа” ба “тусгай мөрдөн байцаах цагдаа” гэж хуваагддаг. Энгийн цагдаа нь Дотоод хэргийн яамны шууд харьяанд ажиллах бөгөөд Олон нийтийн аюулгүй байдлын газрын дарга удирддаг. Харин тусгай мөрдөн байцаах цагдаа нь Мөрдөн байцаах ерөнхий газрын (General Directorate of Investigation) харьяанд ажилладаг бөгөөд эрүүгийн мөрдөн байцаалтыг хариуцаж, дотоодын аюулгүй байдал, мөрдөн шалгах нууц ажиллагааг хэрэгжүүлдэг. Мөн олон нийтийн аюулгүй байдлын цагдаагаас гадна Мутаавиун (Mutawwiun) хэмээх шашны цагдаа байдаг бөгөөд энэ нь хааны шууд удирдлага дор байдаг бөгөөд гол үүрэг нь Исламын шариатыг хууль сахиулах явдал юм.

Саудын Арабын цагдаагийн системийн нэг чухал онцлог нь Саудын Арабын зэвсэгт хүчнээс ялгахад их бэрхшээлтэй. Илэрхэлбэл, цагдаагийн чиг үүргийг Саудын Арабын Индэсний харуул, зэвсэгт хүчин ихээр дэмждэг

2. Хятад. Хятад улс бол төвлөрсөн зохион байгуулалттай, нэгдмэл удирдлагатай цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын үүр нэг загвар юм. Нийгмийн аюулгүй байдлыг хамгаалах яам нь Төрийн Зөвлөлийн дэргэдэх нийгмийн аюулгүй байдлын ажлыг улсын хэмжээнд хариуцдаг чиг үүрэг бүхий байгууллага юм. Тус яам нь дотоод аюулгүй байдал, тагнуул,

терроризмтой тэмцэх, цагдаагийн  йл ажиллагаа, хорих анги, улс т р, эдийн засаг, харилцаа холбооны аюулг й байдал зэрэг салбар хариуцсан чиг   рэг б хий хэлтэстэй.

Нийгмийн аюулг й байдлын хэлтс  дийг муж, автономит мужуудад, нийслэлийн нийгмийн аюулг й байдлын товчоонуудыг шууд хотын захиргаанд, нийгмийн аюулг й байдлын товчоо буюу хэлтэс нь хот, мужид, нийгмийн аюулг й байдлын товчоонууд нь орон нутгийн засаг захиргаа, нийгмийн аюулг й байдлын дээд байгууллагуудын удирдлаган дор муж, хошуунд, дэд товчоонуудыг хотын дэд б с нутагт т рийн аюулг й байдлын дээд байгууллагуудын шууд удирдлаган дор тус тус байрладаг¹.

3. Нэгдсэн Вант Улс. Англи, Шотланд, Умард Ирландаас б рдсэн Нэгдсэн Вант Улс (Их Британи) нь дэлхийн хамгийн эртний ардчилсан б г д “олон нийтийн з вш  р л”¹² -ийн (policing by consent) зарчим дээр тулгуурлан  йл ажиллагаагаа хэрэгж  лдэг³. Их Британийн цагдаагийн байгууллага нь олон удирдлагатай, т вл рс н бус цагдаагийн х чний байгууллага юм. Их Британид  ндэсний цагдаагийн алба байдаг й б г д 43 бие даасан цагдаагийн байгууллага  йл ажиллагаагаа хэрэгж  лдэг.

Их Британид “гурван талт хариуцлагын тогтолцоо”-той б г д цагдаагийн  йл ажиллагаа нь жигд явагддаг.

> Дотоод хэргийн алба нь цагдаагийн байгууллагыг санх  ж  лдэг б г д цагдаагийн  йл ажиллагааг удирдан, зохион байгуулдаг.

> Цагдаагийн эрх баригчид олон нийтийн х чийг  р д нтэй ажиллуулахыг зохион байгуулдаг.

> Цагдаагийн газрын дарга нар б с, нутгийн х чийг удирдан чигл  лэх, хяналт тавих   рэгтэй.

Их Британийн Дотоод хэргийн яамны мэдээлснээр энэ систем нь цагдаагийн байгууллагад улс т рийн х ндл нгийн оролцоог багасгах, т  нээс сэргийлж нэг байгууллагад цагдаагийн б хэл б тэн эрхийг  г  х  с зайлсхийдэг гэж  здэг.

¹ https://en.wikipedia.org/wiki/Law_enforcement_in_China

² Энэ нь цагдаа з вх н х чээр дэг журам тогтоохоос ил   олон нийтийн итгэлийг олж авах  ндсэн дээр хууль ёсны байдлаа баримталдаг гэсэн  г юм.

³ https://en.wikipedia.org/wiki/Law_enforcement_in_the_United_Kingdom

4. Испани: Испани бол олон удирдлагатай, нэгдмэл бус, тлвлрсн цагдаагийн байгууллагын нэг жишээ юм. Европын бараг бх улс орны нэгэн адил цагдаагийн йл ажиллагаа нь “хуулийн дагуух цагдаа” (policing by law/)-ийн гэсэн зарчимд суурилдаг. Тус улсад олон удирдлагатай, тлвлрсн, нэгдмэл бус зохион байгуулалтайгаар цагдаагийн байгууллагын йл ажиллагаагаа хэрэгжлдэг байна.

Хууль сахиулах байгууллагын  йл ажиллагаагаа  ндсэн хуулийн дагуу хэрэгж  лдэг б г  д олон нийтийн аюулг й байдлын б тцийг тодорхойлох эх сурвалж болдог. Испанийн  ндсэн хуулийн дагуу олон нийтийн аюулг й байдлыг хангах нь з вх н т рийн   рэг б г  д аюулг й байдлыг хангах  ндэсний засгийн газрын   рэг гэж тодорхойлсон юм.

Испанид Үндэсний цагдаа байдаг бөгөөд энэ нь иргэний хөчин бөгөөд Үндсэндээ хот суурин газарт ажилладаг. Иргэний харуул нь гол төлөв хөдөл, орон нутагт ийл ажиллагаа явуулдаг.

5. Америкийн Нэгдсэн Улс: Цагдаагийн байгууллагын Үйл ажиллагааг муж, орон нутгийн Үндсэн дээр зохион байгуулдаг бөгөөд Үндэсний цагдаагийн алба гэж АНУ-д байдаггүй. АНУ-ын эрүүгийн шүүхийн тогтолцоо нь шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хууль сахиулах Үйл ажиллагаа гэсэн 3 Үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг. Хэдийгээр бүрэлдэхүүн хэсэг тус бүр нь хагас бие даасан байдлаар ажилладаг ч эдгээр нь нийлээд мөрдөн шалгах ажиллагаанаас эрүүгийн ял оногдуулах хэртэлх бүхий л Үйл ажиллагааг хамааруулан үздэг¹.

АНУ-д хууль сахиулах байгууллагууд нь т᠋᠋ вл᠋ рс᠋ н бус зохион байгуулалттай байдаг б᠋᠋ г᠋᠋ д холбооны цагдаагийн байгууллагууд ᠋᠋ рсдийн эрх мэдэлд хамаарах холбооны хуулийг з᠋᠋ рчс᠋ н асуудлуудыг шийдвэрлэдэг. Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын онцлог нь 2-3 ажилтантай албан бус жижиг хэлтсээс эхлээд олон салбар хэлтэс, олон мянган ажилтантай нийслэлийн цагдаагийн газар х᠋᠋ ртэлх ихээхэн онцлогтой зохион байгуулалтын б᠋᠋ тэцтэйгээр ᠋᠋ йл ажиллагаа хэрэгж᠋᠋ лдэг. Цагдаагийн б᠋᠋ тэц нь холбооны, мужийн, орон нутгийн т᠋᠋ вшинд ихээхэн ялгаатай байдаг.

¹ https://en.wikipedia.org/wiki/Law_enforcement_in_the_United_States

6. Энэтхэг. Дэлхийн улс орнуудад хамгийн их цагдаагийн тоогоор тэргүүлдэг улсуудын тоонд ордог бөгөөд 1,032,960 цагдаатай байна. Удаах байранд АНУ, Их Британи, Франц зэрэг улсууд тус тус оржээ. Энэтхэгийн цагдаагийн байгууллагын загвар нь олон тооны командлагчтай, зохицуулалтгүй, төвлөрсөн бус цагдаагийн жишээ юм. Их Британийн “олон нийтийн зөвшөөрөл”-ийн зарчим дээр суурилсан цагдаагийн үйл ажиллагааны зарчмаас эрс ялгаатайгаар зохион байгуулагддаг. Энэтхэг улс цагдаагийн үйл ажиллагааг хуулийн үндсэн дээр хэрэгжүүлдэг.

Дүгнэлт. Гадаадын зарим орны цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын загварыг харьцуулан зэхэд тухайн орны төрх, нийгэм, соёл, эрх зүйн тогтолцоо, нутаг дэвсгэрийн харьяалал зэргээс хамааралтай байна. Жишээлбэл, парламентын ардчиллын эртний уламжлалтай Их Британид цагдаагийн алба нь “олон нийтийн зөвшөөрөл”-ийн зарчмаар ажилладаг бөгөөд бусад ихэнх улс орны нэгэн адил цагдаагийн эрх мэдлийг хуулиараа төрд хадгалдаг. Дэлхийн цагдаагийн байгууллагын нийтлэг шинж чанаруудыг тодорхой онцлог, шинжийн үндсэн дээр гаргаж ирэхийг оролдсон бөгөөд үүний илэрэл нь зохион байгуулалтын загвар юм. Эдгээр нийтлэг шинжийг нэгтгэн үзвэл:

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “хууль ёсны үндэслэл”-ийг дараах байдлаар ангилдаг байна. Үүнд:

- “Олон нийтийн зөвшөөрөл” буюу “Policing by consent”;
- “Хуульд үндэслэсэн цагдаа” буюу “Policing by law”.

2. Удирдлагын онцлогт суурилсан ангилал. Үүнд:

		Төвлөрсөн	Төвлөрсөн бус
	Нэг удирдлагатай	Хятад Саудын Араб	-
Олон командлагчтай	Уялдаатай болон (Coordinated)	Франц	Их Британи
	Уялдаагүй (Uncoordinated)	Spain	АНУ Энэтхэг

Энэхүү загвар, ангилал нь хоёр хэмжигдэхүүн дээр суурилдаг.

А. Удирдах хичний тоо. Тухайн улсын хэмжээнд нийт цагдаагийн бие бүрэлдэхүүн нэг удирдагчийн дор нэгдсэн нэг хич болон зохион байгуулагдаж байвал уг загварыг “Singular” буюу нэг удирдлагатай загвар, хэрэв нэг улсад хэд хэдэн цагдаагийн байгууллага байхаас гадна олон удирдлагатай байвал “Multiple

model” буюу “олон удирдлагатай загвар” гэж нэрлэдэг. “Олон удирдлагатай загвар” нь удирдлагын хоорондын харилцан уялдаанаас хамаарч уялдаатай болон уялдаагүй загвар гэж ангилдаг. Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаа нь хоорондоо давхцдаггүй, харилцан хамааралтай ажилдаг бол энэ загварыг “уялдаатай, олон удирдлагатай загвар” гэж нэрлэдэг бөгөөд үүнээс эсрэгээр үйл ажиллагаа нь хэрэгжиж байвал нь “олон удирдлагатай, уялдаагүй загвар” гэж үздэг байна.

Б. Зохион байгуулалтын төрөл. Энэ нь зохион байгуулалтын онцлогоос хамаарч төвлөрсөн болон төвлөрсөн гэж ангилдаг. Энэ цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын онцлогоос хамааран ангилан авч үздэг. Үүрээр хэлбэл, зарим орны цагдаагийн байгууллага нь нэгдмэл уялдаатай, төвлөрсөн, зохион байгуулалттай байдаг бол зарим улсын хувьд цагдаагийн байгууллага нь төвлөрсөн удирдлагын бүтэцгүй, олон удирдлагатай байдаг бөгөөд үүнийг төвлөрсөн бус цагдаагийн байгууллагын ангилалд хамааруулж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Долгорсүрэн Ж, Булган Д. Монгол Улсын цагдаагийн эрх зүйн курс. УБ., 2014.

Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл. 2015. №8.

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бодловчийг шинэчлэн батлах тухай Монгол Улсын их хурлын тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail/15488>

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2019, 2020, 2021 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. <https://police.gov.mn/as/static>

Monica den Boer, Changwon Pyo. “Good Policing: Instruments, Models and Practices” ISBN : 978-981-08-8126-9, Copyright@2011, p 17.

European Code of Police Ethics, www.polis.osce.org

<https://en.wikipedia.org/>